

"МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ" -ИЙН ТАЙЛАН

№	Бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ[1]	Төсөв /сая төг/[2]		Хэрэгжилт[6]	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэл ийн хувь[7]	Тайлбар (Хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)[8]
		Төсөв	Гүйцэтгэл			
0	1	2	3			
Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.						
Зорилт 2.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ:						
1	2.3.1. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.	-	-	Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, гэр бүлийн бүтэц, хэв маяг, гэр бүлд гарч буй өөрчлөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, гэр бүлийн харилцааны тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор “Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгааг хийсэн. Судалгааны тайланд үндэслэн хүн амын өсөлт, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, гэр бүлийн хүүхдийн тоотой уялдуулан гэр бүлд татварын хөнгөлөлт, орон сууцны дэмжлэг үзүүлэх, иргэдийн ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангах, гэр бүлийн гишүүдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн үйлчилгээг цогцоор хүргэх, гэр бүлийг дэмжих зэрэг зохицуулалтуудыг тусгасан Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулан Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог анхан шатанд бэхжүүлж Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолоор 2024 оноос эхлэн хүүхэд, гэр бүлийн 833 нийгмийн ажилтан аймаг, дүүрэг, сум, хороодод ажиллах асуудлыг шийдвэрлэсэн. Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн үйл ажиллагаа, гэр бүлд хөгжлийн үйлчилгээг гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн байгууллага, Гэр бүлд зөвлөгөө өгөх 31 төв үзүүлж, 2020-2024 онд нийт гэр бүлийн 25%-д хүрч ажиллаж байна. Гэр бүлийн боловсролын сургалтын хөтөлбөр, модул, гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг боловсруулан хэрэгжүүлж байна. Түүнчлэн төсвийн зардлыг үр ашигтай зарцуулах, иргэдэд хөгжлийн үйлчилгээг цогцоор үзүүлэх зорилгоор аймаг, дүүрэгт байгаа хүн амын, хүүхэд, залуучуудын, ахмадын, соёлын гэх мэт салангид бүтцийг оновчтой байдлаар нэгдсэн зохион байгуулалтад оруулах, эдгээр төвийн байшин барилгыг ашиглан Гэр бүлийн хөгжлийн цогц төвийг аймаг, нийслэлийн дүүрэгт ажиллуулах зорилт тавин ажиллаж байна. Гэр бүлийн хөгжлийн	100	

				цогц үйлчилгээний төвийн ажиллах заавар, зөвлөмжийг ГБХНХСайдын 2025.04.16-ны А/92 тушаалаар баталсан. Мөн гэр бүлд, хүн амын бүлгүүдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох, иргэний бие даан хөгжих, суралцах боломжийг бүрдүүлэх зорилго бүхий “E-family” цахим платформын хөгжүүлэлтийг хийж байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах, урьдчилан сэргийлэх салбар дундын тогтолцоог бий болгож анхан шатанд 806 Хамтарсан баг, 22 Түр хамгаалах байр, 17 Нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж, шуурхай, хамгааллын, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд үзүүлж байгаа бол аж ахуй нэгж, байгууллагуудад эцэг, эх сургууль хамтран ажиллах нийт 10053 “Эцэг эхийн зөвлөл” байгуулагдан ажиллаж, тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.		
2	2.3.2. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшилийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.		782,4	2019 оны 11-р сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Хүүхдийн эрхийн тухай хуульд тус тус Хүүхдийн төлөө сантай байхаар заасан бөгөөд уг сан нь хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих зориулалттай байхаар тусгасан. Хүүхдэд зориулсан сангийн хөрөнгийн эх үүсвэрийг авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжсэн соёл, урлаг, спортын тоглолтын орлого, бусад орлогоос бүрдэхээр заасан. Сангийн хөрөнгөөс олон улсын тив дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх зохицуулалт туссан. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан. Уг журмыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/139 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Журмын шинэчлэлд дараах зохицуулалтыг тусгасан. Сангийн санхүүжилтээр дэмжих төсөл, арга хэмжээг: Хүүхдэд зориулсан барилга байгууламж шинээр барих; Хүүхдэд зориулсан барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх; Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зохицуулалт тусган, хүрээг өргөтгөн тогтоосон. Хүүхдийн төлөө сангийн 2021-2025 оны нийт орлого нь 24 тэрбум төгрөг, зарлага нь 782,4 сая төгрөг байна. -Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшилийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог	100	

			нэмэгдүүлж, хүүхдийн хөгжих, оролцох эрхийг ханган ажиллаж байна. -Хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд 2021 онд 12495, 2022 онд 61050, 2023 онд 56720, 2024 онд 102704 хүүхэд, 2025 оны хагас жилийн байдлаар 105776 хүүхэд хамрагдсан. Хүүхдийн зуслангууд 2021 онд /Ковид-19/ цар тахлын үе тул ажиллаагүй. 2022 онд 59378, 2023 онд 73964, 2024 онд 91801 хүүхэд амарсан. -“Хүүхдийн оролцоог дэмжих удирдамж”-ийг 2021 онд батлан хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд хүүхэд гишүүнчлэлтэй өөрийн удирдлагын байгууллага болох Монголын Хүүхдийн Зөвлөлийг 2021 онд байгуулж, өдгөө 20,000 гаруй гишүүнчлэлтэй үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж, хүүхэд бүрийн дуу хоолойг хүргэн ажиллаж байна. Хүүхдүүд оролцох, хөгжих эрхээ эдэлж, хүүхэд, өсвөр үе, залуучуудыг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаанд 2021 онд танхимын болон цахим хэлбэрийн 439 арга хэмжээнд 101542 хүүхэд, 2022 онд танхимын болон цахим хэлбэрийн 251 арга хэмжээнд давхардсан тоогоор 559,489 хүүхэд, 2023 онд 278 сургалт үйл ажиллагаанд 467,265 өсвөр үе хамрагдаж чадавхжсан бөгөөд 2024 онд давхардсан тоогоор 674 удаагийн чуулган уулзалт, зөвлөгөөнд 13277, 1434 удаагийн соёл, спорт арга хэмжээнд 58286, 1318 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт 43364 хүүхэд оролцсон -Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6.5-д “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага үйлчилгээний бодлого, хөтөлбөртэй байх бөгөөд эрх бүхий этгээдээс баталсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллана” гэх заалтын хүрээнд “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын (ТХ 46) хороогоор хэлэлцүүлэн батлуулсан. -2021 онд УИХ-аас баталсан 2022 оны Төсвийн тухай хуулийг дагалдан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.5-т "хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтарч батална" гэж нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ХНХСайдын 2021 оны А/218 тушаалаар "Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам", "Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг төлөвлөх, санхүүжүүлэх аргачлал"-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар тус тус батлан хэрэгжилтийг ханган ажилласан.	
--	--	--	---	--

			-Хүүхэд хамгааллын тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн 14 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын чуулганы 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталж, 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Уг хуулиар хүүхэд хамгааллын тогтолцоог Хүүхдийн эрхийн тухай хуультай нийцүүлэн боловсруулж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн бүх байгууллага хүүхэд хамгааллыг дэмжих, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй болсон. Мөн тус хуулийн хоёрдугаар бүлэгт хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр, хүүхэд хамгааллын кейс менежмент, хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг шинээр тодорхойлж, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх эрх зүйн зохицуулалттай болсон. -Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд сум, хороо бүрт хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллах эрх зүйн зохицуулалттай болж, Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоолоор улсын хэмжээнд нийт 833 нийгмийн ажилтан ажиллах орон тоог баталсан. 2025 оны хагас жилийн байдлаар 751 нийгмийн ажилтан сум, хороонд ажиллаж байна. Шинээр томилсон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг улсын хэмжээнд 2025 оны 2-р сард бүсчлэн зохион байгуулсан. -2025 оны хагас жилийн байдлаар аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хэлтсээс Хамтарсан багийн гишүүд, боловсролын, халамжийн, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудад хүүхэд хамгааллын кейс менежментийн арга зүйг түгээх сургалтыг сум, хорооны Засаг дарга, Хамтарсан багтай хамтран зохион байгуулж, 9 дүүргийн 225 хороо, 17 аймгийн 122 сумын 602 хамтарсан багийн 2882 гишүүдэд хүргэсэн. - ГБХНХЯ, Сангийн яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар хамтран Засгийн газрын 2024 оны 236 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив”, Хүүхэд хамгааллын тухай хуулийг даган батлагдсан журам, стандартыг хэрэгжүүлж, мөрдөх арга зүйн сургалт зохион байгуулж, аймаг, нийслэл, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар/хэлтсийн 120 албан хаагч, сум, хорооны 623 нийгмийн ажилтныг чадавхжуулсан. Мөн Сангийн яам, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Хүүхэд хамгааллын санхүүжилтийн цахим модуль”-ийг боловсруулж, албан хаагчдад сургалт зохион байгуулж, 2025 оны 07 дугаар сарын 01-ээс эхлэн ашиглаж эхэлсэн.	
--	--	--	---	--

				-Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ авсан үйлчилгээ авсан нийт хүүхэд 2022 онд нийт 25487, 2023 онд 31501, 2024 онд 28658 хүүхэд байна. 2025 оны хагас жилийн байдлаар хүүхдийн эрх, хамгааллын 8015 кейсийг нээж, кейс шийдвэрлэлт 57.8 хувьтай байна. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг 331348 хүүхэд, 119,000 эцэг эхэд үзүүлсэн байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч 1267 хүүхдэд үйлчилгээг үзүүлж байна. - Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого” болон Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Улсын хэмжээнд 4579 байгууллага, аж ахуй нэгж Хүүхэд хамгааллын бодлого баталж, 10053 байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулагдаж, 1014 байгууллага хүүхдийн өрөө тохижуулж, 103 байгууллага дэргэдээ хүүхдийн цэцэрлэг байгуулан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн. Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийг арга зүйн удирдлагаар хангах, эцэг эхийн зөвлөлийн гишүүдээр дамжуулан гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээх, эцэг эхчүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг тогтмолжуулж, 126 байгууллагын 23,816 албан хаагчдад гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулан мэдлэг олгосон.		
3	2.3.3. Залуу гэр бүлийг дэмжсэн орчин нөхцөл сайжирна.	-	-	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 18 дугаар тогтоолоор баталж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, залуучуудын хөгжил, оролцооны асуудлыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудалд хамааруулсан тул ССАЖЗЯ гаргана	-	ССАЖЗЯ
4	2.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.	1. 59.8 тэрбум /Улсын төсөв/ 2. 15.4 тэрбум /Улсын төсөв/	1. 38.1 тэрбум /Улсын төсөв/ 2.78.2 сая /Улсын төсөв/	1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллах, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох, ажил олгогчийг дэмжих болон тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар тэднийг байнгын ажлын байраар хангах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж байна. 2021-2025 оны 05 дугаар сарын байдлаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт нийт 18948 иргэн хамрагдаж, 38.1 тэрбум төгрөг зарцуулж, 5396 иргэн ажлын байраар хангагдсан байна.	100	

		3. 11.3 тэрбум /Гадаадын зээл, тусла мж/	3. 11.3 тэрбум /Гадаадын зээл, тусламж/	2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/48 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарлсантай хобогдуулан 43 арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 20 хувьд хүргэх, 2000 гаруй хүнийг байнгын ажлын байртай, тогтвортой орлоготой болгох, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг 12,0 мянган хүнд хүргэх, 500-аас багагүй ажил олгогчтой хамтран ажиллана. Мөн жилийн хүрээнд салбар дундын уялдааг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн, тэдний онцлог, хэрэгцээ, ур чадварт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэх, иргэд, ажил олгогчдын ойлголт, хандлагыг сайжруулах, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/82 дугаар тушаалаар 6 бүсд зохион байгуулахаар баталсан. 2025 оны 06 дугаар сарын байдлаар Хөвсгөл, Дундговь аймгуудад бүсийн цогц арга хэмжээг хэрэгжүүлээд байна. 3. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр L3605/G9191-MON48076-002: “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар хотод Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төв байгуулаад байна. 2025 оны 05 сарын байдлаар 54 хүнд хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээ хийж, үзүүлэлт тус бүрт асван оноогоор бие махбоди, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, өөрийгөө удирдах, нийгмийн харилцааг тус тус тодорхойлж, үр дүнг тооцож гаргасан. Үнэлгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бэрхшээлийн төрлөөр нь авч үзвэл: сонсгол-18, хараа-6, хөдөлгөөн-21, оюун ухаан-8, бусад—1 Үүнээс хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр шууд ажиллах боломжтой 4 хүнийг ажлын байранд зуучилж, хөдөлмөрийн гэрээг байгуулсан. Хөдөлмөрийн харилцаатай холбоотой гэрээ байгуулах, ажлын байранд хийгдэх ажил үүрэг гэх мэт хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дэмжлэгийн туслалцааг тогтмол үзүүлж ирсэн. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих юм.		
--	--	--	---	--	--	--

			“Хөдөлмөрийн бирж”-ээр дамжуулан 2021, 2022 онуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд зуучлах, ажлын байрны захиалга авах, бүртгэх хүрээнд нийт хөгжлийн бэрхшээлтэй 1003 иргэн Хөдөлмөрийн биржээр үйлчлүүлсэн. Үүнээс 453 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл хүргэж, 412 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг баталж, Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа, Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, Түр ажлын байрыг дэмжих болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа зэрэг 5 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан. ХЭҮЗ-ийн тогтоолыг үндэслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/50 дугаар тушаалаар хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа /хөтөлбөр/-ны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг, А/52 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваарийг тус тус баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 3518 иргэнийг хамруулж, 15.7 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 966 иргэн хамрагдаж 2,095,581,900 төгрөг зарцуулсан. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд: 1. Хувиараа хөдөлмөр эрхлэх ахмад настанд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг өмнөх жилүүдийнхээс нэмэгдүүлсэн. 2. Ахмад настны зөвлөх үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлсэн. 3. Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх ахмадуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажиллаж байсан ажил мэргэжлийн чиглэлийг заахгүйгээр сонгон шалгаруулж ажиллах боломжийг бүрдүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 353 иргэн хамрагдаж, 106,195,800 төгрөг зарцуулсан. Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан.	
--	--	--	--	--

				Уг хуульд ахмад настý хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад настны хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх зэрэг тодорхой өөрчлөлтүүдийг тусгасан. Тухайлбал: • ахмад настныг авч ажиллуулж байгаа байгууллага тэтгэврийн даатгалын шимтгэл 8.5 хувийг төлөхгүй байх; • тэтгэвэрт гарсан эмч, багш зэргийг өөрсдийн хүсэлтээр үргэлжлүүлэн ажиллахыг дэмжих, энэ хүрээнд Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох Засгийн газрын гишүүнтэй хамтран дээрх чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, тухайн салбарын батлагдсан төсвөөс санхүүжүүлэх; Энэ хүрээнд ЭМС, БШУС-тай хамтран төлөвлөгөө боловсруулахаар 2025 оны 05 дугаар сарын 22-ний өдөр Ажлын хэсгийн хурал зохион байгуулсан. Төлөвлөгөөний төсөл боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. • 50 ба түүнээс дээш ажилтантай байгууллага нэг ахмад настныг авч ажиллуулах; • мод, хүнсний ногоо тарих зэрэг байгаль орчны болон хүнс үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт ахмад настныг ажиллахыг дэмжиж хөнгөлөлттэй зээл олгох, цалин хөлсийг зах зээлийн ханшаар ажилласан хугацаанд тооцон цагаар, өдрөөр гэх мэт уян хатан хэлбэрээр олгох, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг өргөжүүлэх тогтолцоо бүрдсэн. Ахмад настны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 124 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын ахмадын холбоотой жил бүр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.Энэ хүрээнд Ахмад настанд ая тухтай, ээлтэй орчин бүрдүүлж чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, амьдралын эерэг зан үйл, зөв хэвшилд суралцахад нь чиглэсэн сургалт, олон нийтийн арга хэмжээг аймаг, дүүргийн ахмадын ордон, өргөө, төв, танхимаар соёл, спорт, соён гэгээрүүлэх зэрэг олон төрлийн арга хэмжээ зохион байгуулсан байна.Үүнд: - 2023 оны байдлаар 306,212 ахмад настан буюу 84 % - 2024 онд 315,000 ахмад настан буюу 81,7 хувь хамрагдаж соёл,спорт, соён гэгээрүүлэх 2025 оны хагас жилийн байдлаар нийт 31,488 ахмад оролцсон нь нийт ахмадын 8.1 хувийг эзэлж байна.		
5	2.3.5. хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид	58.4 тэрбум	58.4 тэрбум	1/ 2020 онд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал судалгаа, Хүүхэд хамгааллын	100	

байлгах чиглэлээр эрх зүйн орчныг чангатгаж, хэрэгжилтэд хатуу хяналт тавих тогтолцоог бий болгоно.

үйлчилгээний зураглал судалгааг тус тус хийж, үр дүнг хэлэлцүүлсэн.

-2021 онд УИХ-аас баталсан 2022 оны Төсвийн тухай хуулийг дагалдан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.5-т "хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтарч батална" гэж нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ХНХСайдын 2021 оны А/218 тушаалаар "Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам", "Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг төлөвлөх, санхүүжүүлэх аргачлал"-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар тус тус батлан хэрэгжилтийг ханган ажилласан.

-Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлэх 14 хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2023 оны 10 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихыг дэмжсэн.

- Хүүхэд хамгааллын тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн 14 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын чуулганы 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталж, 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

-Хүүхэд хамгааллын тухай хуулийн зорилго нь хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино. Хуулиар гэр бүл, нийгмийн бүх орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүүхэд хамгааллыг дэмжих, хэрэгжүүлэх үүргийг хуульчилсан. Тухайлбал,

Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлсэн.

Гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг өргөжүүлж, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг, оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлж, мөн хүүхдийн амьдарч байгаа орчин, орон байранд архидан согтуурах, согтуурсан үедээ нэвтрэхийг хориглосон.

Эцэг эх хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүүхдээр тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон.

Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулж, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээг хуульчилсан.

Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллыг тусгаж, үүнтэй уялдуулан Зөрчлийн тухай хуульд холбогдох шийтгэлийг оногдуулсан.

Хурдан морины уралдаанч хүүхдийн хамгаалал, гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын зохицуулалтыг шинээр хуульчилж, үүнтэй уялдуулан Зөрчлийн тухай хуульд холбогдох шийтгэлийг оногдуулсан.

Салбар бүр хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусган хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалттай болсон.

Хуулийн 30.5-д “Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” Гэж заасан.

Мөн сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллах эрх зүйн зохицуулалттай болж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн ажиллаж, 2025 оны 6 сарын байдлаар 751 нийгмийн ажилтан ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийг даган гарах 1 дүрэм, 6 журам, 3 аргачлал, заавар, норматив, 3 стандарт Хүүхдийн эрхийн тухай хуулийг даган гарах 1 дүрэм, мөн “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоо”, 1 стандарт батлагдсан.

-Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, УИХ-аас 2024 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/ хамт Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдаж, хуулийн 20 дугаар зүйлд хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх зүйн байдал, хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих шинэ зохицуулалтууд туссан. Үүнд:

Хуулийн 20.4.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийн эрх хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, шалган шийдвэрлэх замаар хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангуулна.

Хуулийн 20.11.Хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон, орсон байж болзошгүй тохиолдолд хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламж, ажлын байр, орон байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөтэй нэвтрэх эрхтэй.” гэж хуульчилсан.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ЗГ-ын 2024 оны 142 дугаар тогтоолоор “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах

дүрэм”, ЗГ-ын 2024 оны 143 дугаар тогтоолоор “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоо”-г батлуулсан. ЗГ-ын 2024 оны 143 дугаар тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхлэх бөгөөд улсын хэмжээнд 92 улсын байцаагч ажиллана.

Хүүхдийн эрхийн улсын байцаагчид нь Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1-5, 8-13 дахь хэсэг, 14.1 дүгээр зүйлийн 13 дахь хэсэг, 14.15 дугаар зүйлийн 4-6 дахь хэсэг, 6.28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, хуулийн 10.23 дугаар зүйл буюу Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль зөрчих, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэж байна.

Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 25.10, 26.4, 26.5, 34.1.15, 47.4, 47.5, 55 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 142.5 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэгтэй ажиллаж байна.

ГБХНХ-ын сайдын 2025 оны А/17 дугаар тушаалаар “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2025 оны урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын төлөвлөгөө, ГБХНХ-ын сайдын 2025 оны А/121 дүгээр тушаалаар Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг хангуулж байна.

Хүүхдийн эрхийн улсын байцаагчид 2023 онд 189, 2024 онд 127, 2025 оны хагас жилийн байдлаар 108 зөрчлийг шалган шийдвэрлэсэн.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журмын дагуу хүүхдэд төрөөс олгож буй мөнгө хүүхдэдээ зарцуулагдахгүй, эрх нь зөрчигдсөн өргөдөл, гомдлыг шалган шийдвэрлэж, дүгнэлт гаргаж байна. 2023 онд 686, 2024 онд 727, 2025 оны хагас жилийн байдлаар 531 гомдол ирснээс 435 гомдлыг шийдвэрлэсэн.

Хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд 2023 онд 364 хяналт шалгалтаар 618 хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг илрүүлсэн. 2024 онд 136 урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 3586 аж ахуйн нэгжийг хамруулж, 430 хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 35 зөрчилд хариуцлага тооцсон байна. Эрүүгийн хуулиар 3 хэрэг шалгуулсан. 2025 оны хагас жилийн байдлаар урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтаар 116 хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлж, хөдөлмөр эрхлэгч хүүхэд, түүний гэр бүлд шаардлагатай дэмжлэг, үйлчилгээг 100% үзүүлж, холбогдох зардлыг хүүхэд хамгааллын зардлаас шийдвэрлэсэн.

Хүүхдийн хөгжил, хамгааллын зардлыг жил бүр нэмэгдүүлж, 2021 онд 8.0 тэрбум төгрөг, 2022 онд 8.0 тэрбум, 2023 онд 7.9 тэрбум,

				2024 онд 13.9 тэрбум төгрөг, 2025 онд 20.6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс баталсан.		
Зорилт 2.6. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ:						
6	2.6.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгоно.	-	-	1. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалгааг Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу хийж гүйцэтгэсэн. Судалгаатай холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлууллаа. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2025 оны 5 дугаар сард яамдаас санал авч нэгтгэлээ. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох бусад баримт бичгийг Засгийн газрын хэрэглэх газарт 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар уг хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барих нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. 2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/21 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах техникийн ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийж гүйцэтгэсэн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/88 дугаар тушаалаар хуулийн төслийг эцэслэн боловсруулах, хэлэлцүүлэх үүрэг бүхий өргөтгөсөн ажлын хэсгийг хөдөлмөр, нийгмийн түншлэгч талууд болон холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, холбогдох байгууллагуудтай хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг авч хуулийн төсөлд тусгасан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар салбарын яамд	90	

				болон холбогдох байгууллагуудад 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/1789, 01/1803 тоот албан бичгээр тус тус хүргүүлж саналыг авч ажиллаж байна. Мөн Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичгийг 2025 оны 01/1879 тоот албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх албан бичгийг, ЗГХЭГ-т 2025 оны 01/1888 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хөдөлмөрийн тухай болон Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлтэй холбогдуулан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”, “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”, “Ажилласан хугацааг тооцох журам”, “Ажлын цагийг нэгтгэн бодох журам”, “Төрийн албан хаагчдад нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журам” зэрэг нийт 20 дүрэм, журмыг батлуулан батлуулсан. Мөн төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарт гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлээд байна. Түүнчлэн хөдөө, орон нутагт төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах хүрээнд хөдөөгийн суманд ажиллаж байгаа 51.8 мянган төрийн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувь, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа 53.4 мянган төрийн албан хаагчид сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож орон нутгийн нэмэгдлийг нийт 105.2 мянган төрийн албан хаагчид олгож байна. Мөн төрийн захиргааны болон үйлчилгээний албанд анх ажилд орсон албан хаагч тасралтгүй 5 жил ажилласны дараагаас ажилласан жилийн нэмэгдэл авч эхэлдэг байсныг өөрчилж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг жил бүрээр бодож олгодог болсон. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баталж, орон нутагт тогтвор, суурьшилтай ажилласны урамшууллыг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны байгууллагад болон алслагдсан гурван дүүрэгт 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид олгож эхлээд байна.		
7	2.6.2. Ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг	289,3 тэрбум төгрөг	187,8 тэрбум төгрөг	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. Тус хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нийтдээ 24 сар ба түүнээс дээш хугацаанд, үүнээс ажилгүй болохын өмнөх сүүлийн 9 сар	90	

	нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.			тасралтгүй төлсөн, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрээгүй даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй” гэж зохицуулсан. Мөн зүйлийн 9.2 дахь хэсэгт “Ажилгүйдлийн тэтгэмж урьд нь авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг дахин 12 сар, үүнээс ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн бол ажилгүйдлийн тэтгэмж авах эрх дахин үүснэ” гэж заасан. Дээрх хуулийн заалт хэрэгжсэнээр ажилтныг ажилгүй болоход нь тодорхой хугацаанд эдийн засгийн хувьд дэмжих, амьжиргааг нь хангах, мөн шинэ ажлын байр хайх хугацаанд нь санхүүгийн дарамтыг багасгах ач холбогдолтой зохицуулалт юм. Хуулийн шинэчлэлээр ажилгүйдлийн тэтгэмж бодох хувь хэмжээг нэмэгдүүлэх, мөн ажлын байрны тогтвортой байдлыг дэмжиж, даатгуулагчийг тогтвор суурьшилтай ажиллуулан, 3 жил дараалан ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн 15 хувиар тооцож, ажил олгогчид 3 жил тутамд нэг удаа шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхээр тусгасан. Ажилгүйдлийг бууруулах, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, “Халамжаас-хөдөлмөрт” зорилтын хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмэгтэйчүүд, залуучууд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэн, малчин зэрэг зорилтот бүлгийн иргэдэд зориулсан хөтөлбөр, арга хэмжээнд 2021-2025 оны 5 дугаар сарын байдлаар нийт 289.3 тэрбум төгрөг төсөвлөж, 187.8 тэрбум төгрөгийг зарцуулж, 119892 шинэ ажлын байр бий болгосон. Үүнээс 37009 байнгын ажлын байр бий болгосон байна.		
8	2.6.3. оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ.	-	-	2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн тухай хуульд ажилтныг гэрээсээ ажиллах, зайнаас ажиллах, бүтэн бус цагаар ажиллах, иргэд хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулах зэрэг зохицуулалт шинээр туссан. Ингэснээр ажилтан, ажил олгогч харилцан тохиролцон хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон уян хатан зохицуулалтыг хэрэглэх боломж бүрдсэн. 2021-2025 оны 05 сар хүртэлх хугацаанд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 309.7 тэрбум төгрөг зарцуулж, давхардсан тоогоор 676.2 мянган хүн хамрагдаж, 161.0 мянган хүнийг байнгын болон түр ажлын байраар хангасан байна.	50	
9	2.6.4. албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.	-	-	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор албан бусаас албан салбарт ажиллагсдыг дэмжих зорилгоор хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон гадаад улсад	30	

				хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэдэд зориулсан бага хүүтэй жижиг зээлийг олгохыг баталдаг. Тухайлбал, 2022 онд 20 тэрбум төгрөг, 2024 онд 13 тэрбум төгрөг, 2025 онд 45 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгохоор төсөвлөж 2022-2024 онд 1500 иргэнд 33 тэрбум төгрөг олгож, 3000 гаруй ажлын байрыг бий болгох, хадгалахад дэмжлэг үзүүлсэн байна. 2025 онд жижиг зээл олгохоор ХХҮЕГ банк сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, гарааны бизнес эрхлэгчийг дэмжих жижиг, дунд бизнесийг дэмжих зээл, зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 267 дугаар тогтоолоор батлуулсан.		
10	2.6.5. төрийн албан хаагчдын цалинг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	-	-	Үндэсний статистикийн хорооны 2024 оны мэдээгээр нийт ажиллагчдын дундаж цалин хөлс 2,332.4 мянган төгрөг, хувийн хэвшлийн ажиллагчдын дундаж цалин хөлс 2,303.8 мянган төгрөг, төрийн албан хаагчдын дундаж цалин хөлс 2,278.0 мянган төгрөг байна. Монгол Улсын Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дунджаар 40 хувиар, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10-20 хувиар, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Мөн цалингийн сүлжээг оновчтой болгох хүрээнд нийт 153 ялгаатай цалин тогтоож байсныг өөрчлөн төрийн захиргааны албан тушаалын 15 зэрэглэлийг 10, төрийн тусгай албаны 18 зэрэглэлийг 12 болгон нягтаршуулсан. Мөн төрийн захиргааны болон үйлчилгээний албанд анх ажилд орсон албан хаагч тасралтгүй 5 жил ажилласны дараагаас ажилласан жилийн нэмэгдэл авч эхэлдэг байсныг өөрчилж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг жил бүрээр бодож олгодог болсон. Түүнчлэн хөдөөгийн суманд ажиллаж байгаа 51.8 мянган төрийн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувь, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа 53.4 мянган төрийн албан хаагчид сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож орон нутгийн нэмэгдлийг нийт 105.2 мянган төрийн албан хаагчид олгож байна.	100	

				Эдгээр арга хэмжээний үр дүнд дундаж цалингийн хэмжээ 2020 онтой харьцуулахад 2.0 дахин нэмэгдэж 2.3 саяд хүрсэн нь 2022-2025 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөө юм.		
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА						
Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.						
Зорилт 3.1. Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ:						
11	3.1.1. нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.	-	-	Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжснээр олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн даатгалын тогтолцоог хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжүүлэх, тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх, тэтгэврийн даатгалын нэрийн дансны хийсвэр бичилтийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогоос өвлүүлэх, тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, төлсөн шимтгэлтэй уялдаатай тэтгэвэр авах, тэтгэврийн доод хэмжээг Засгийн газраас тогтоох зэрэг томоохон өөрчлөлтийг хийх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн.	100	
12	3.1.2. Иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болж, дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэл хийгдэнэ	-	-	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх”-ээр хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих эрх зүйн орчин бүрдсэн. Хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2024 оноос даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц санг үүсгэж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн ажил олгогчийн төлөх 1.0%, даатгуулагчийн төлөх 1.0%, нийт 2.0%, мөн сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын 2.0%-ийн шимтгэлийг хуримтлуулж эхэлсэн. Энэ хүрээнд Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлж буй 1.2 сая даатгуулагч бүр “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал”-тай болж 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 214.8 тэрбум төгрөгийн бодит мөнгөн хуримтлал үүслээ. Мөн 2025 оны эхний 5 сарын байдлаар 1 сая даатгуулагчийн 25.0 тэрбум төгрөгийг нэмж хуримтлуулаад байна. “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал”-ын мэдээллээ төрийн үйлчилгээний “E-Mongolia” цахим систем, нийгмийн даатгалын	90	

				байгууллагын цахим систем portal.ndaatgal.mn болон гар утасны “nDaatgal” аппликейшний хэсгээс харах боломжтой болсон. Мөн нас барсан тэтгэвэр авагчийн эхнэр, эсхүл нөхрийх нь өндөр насны тэтгэврийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлдэг болсон.	
13	3.1.3. Нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно.	129.9 тэрбум төгрөг	85.4 тэрбум	Хүнсний эрхийн бичиг олгох журмыг шинэчлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар баталсан. Уг журамд зөвхөн гэрээт дэлгүүрүүдээр үйлчлүүлдэг байсныг болиулж, НӨАТ-ын баримт буюу и-баримт хэвлэдэг 235.0 мянга орчим хүнсний дэлгүүр, зах, бөөний төвөөр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж цахимжууллаа. Тус ажлын хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийг картжуулах, пин коджуулах, пос машины хөгжүүлэлт, хүнсний бүтээгдэхүүнийг бар коджуулах, сервисийн хөгжүүлэлт зэрэг олон ажлыг шат дараатайгаар төр, хувийн байгууллага хамтран зохион байгуулсан. Ингэснээр сард 405.0 сая төгрөг, жилд 4.8 тэрбум төгрөг хэмнэх боломж бүрдсэн. Нээлттэй, ил тод, тэгш хүртээмжтэй, сонголттой, хяналттай болгосон. Сонгон шалгаруулалтад шалгарсан зөвхөн гэрээ бүхий заасан дэлгүүрээр үйлчлүүлдэг байсныг болиулсан. Монгол Улсын хүнсний бүтээгдэхүүнийг бар коджуулах ажлын эхлэл болж байгаа юм. Мөн дата анализ хийх боломж бүрдсэн. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 2021 онд 167.3 мянган иргэнд 31.0 тэрбум төгрөг, 2022 онд 121.9 мянган иргэнд 20.1 тэрбум төгрөг, 2023 онд 100.6 мянган иргэнд 15.5 тэрбум төгрөг, 2024 онд 89.7 мянган иргэнд 13.7 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ. 2025 оны байдлаар 114 сум, 48 хороо хүнсний талонгүй болсон байна. Мөн Нийгмийн халамжийн үйлчилгээг ил тод болгох, иргэдэд чирэгдэлгүй хүргэх үүднээс иргэдээс олон төрлийн бичиг баримт шаардаж, олон хоног зарцуулж, тэтгэвэр, тэтгэмжийн дэвтэр олгон банкнаас очерлон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авдаг байсныг өөрчилж, Нийгмийн халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/-ийг 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс улсын хэмжээнд нэвтрүүлж цахимжуулсан. 2021 оноос ҮСХ, УБЕГ, НДЕГ, ТЕГ, ЭМДЕГ, ЭМЯ зэрэг байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлыг цахимжуулснаар 2024 оны байдлаар нийгмийн халамжийн 64 төрлийн үйлчилгээг цахим системээр дамжуулан олгож байна. Ингэснээр халамжийн нийт үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн 90 гаруй хувь нь цахимаар үйлчилгээ авч байна.	100

			Халамжийн нэгдсэн систем e-halamj.mn цахим системийг хэрэглээнд нэвтрүүлснээр иргэн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах шалгуур нөхцөл хангасан иргэн, хүссэн газраасаа, хүссэн цаг хугацаандаа хүсэлтээ гаргах боломжтой болсон. Мөн үйлчилгээнд хамрагдахаар гаргасан хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын мэдээлэл, тухайн иргэнд үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийг цахимаар харах боломжтой болсноос гадна тухайн иргэнд олгосон мөнгөн дүнгийн мэдээллийг дашбоард хэсэг дээр ил тод харах боломжтой болсон. Мөн иргэн өөрийн хүссэн банкны дансаар дамжуулан авах боломжтой болсон нь үйлчилгээг хүргэх процессыг хялбар болгосон. Нийгмийн халамжийн бүх төлбөрийг Сангийн яамны Төрийн сангаас иргэдийн арилжааны банк дахь дансанд e-halamj системээр дамжуулан шилжүүлдэг болсон нь нийгмийн халамжийн зардлын хяналтыг сайжруулсан. Мөн иргэд ehalamj.mn цахим хуудаснаас гадна e-mongolia, төрийн үйлчилгээний цахим машин “ТҮЦ” машин, ebarimt аппликэйшн ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргах боломжтой болсон юм. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулснаар төрд байгаа иргэний мэдээллийг иргэнээс шаардахгүйгээр цахим системд хувийн хэрэг үүсгэн ажиллахаас гадна мэдээллийн найдвартай байдлыг хангаж, хүний оролцоог багасгах боломжийг бүрдүүлснээр үйлчилгээ ил тод, нээлттэй, чирэгдэлгүй болох боломж бүрдсэн. Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжилтын хүрээнд 2025 онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна: ✓ Халамжийн нэгдсэн системд нийгмийн халамжийн тэтгэвэр, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээ мөнгөн дүнгийн хэмжээг өөрчлөх, нэмэгдүүлэх ✓ Тусгай хэрэгсэл үйлдвэрлэж байгаа байгууллагад зориулсан системийн хөгжүүлэлтийг Халамжийн нэгдсэн системд хийж, тухайн иргэний өмнө авсан тусгай хэрэгслийн үйлчилгээний мэдээллийг харах эрхийг үйлдвэрлэгч 2 байгууллагад нээх, ✓ Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн хүрээнд одон авах болзол хангасан эхэд мэдэгдэл хүргэх ажлыг МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар, E-Mongolia-тай хамтран хөгжүүлж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулснаар иргэд үйлчилгээг хүссэн цагтаа хүссэн газраасаа авах боломж	
--	--	--	--	--

				бүрдэхээс гадна ажилтны болон үйлчилгээ авагч иргэний хувьд цаг хугацааг хэмнэх боломжтой юм.		
14	3.1.4. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	15.7 сая төг Дэлхийн банкны төсөл төгрөг АХБ-ны төсөл 235.0 сая төгрөг Улсын төсөв	15.7 сая төг Дэлхийн банкны төсөл төгрөг АХБ-ны төсөл 235.0 сая төгрөг Улсын төсөв	Нийгмийн халамжийн тухай хуульд ООТА-ыг Үндэсний статистикийн хороотой хамтран баталж, 3 жил тутамд шинэчлэхээр заасны дагуу Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/04 хамтарсан тушаалаар "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал", "Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал"-ыг тус тус шинэчлэн баталсан. Аргачлалыг батлуулахад зөвлөх үйлчилгээнд Дэлхийн банкны төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд ажилласан дотоод зөвлөх үйлчилгээнд 15.7 сая төгрөг зарцуулсан. Шинэчлэн баталсан аргачлал нь өрхийн амьжиргаанд нөлөө үзүүлэхүйц орлогыг орлуулан тооцож болох төрийн байгууллагын мэдээллийг ашиглан өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх боломжийг бүрдүүлсэн. 2022 онд Монгол Улсын Их Хурлын 71 дүгээр тогтоолоор хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан нийт хүүхдийн 91 хувьд олгохдоо өрхийн мэдээллийн нэгдсэн сан болон төрийн мэдээллийн бусад санг ашиглан бүрдүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн түүнчлэн уг аргачлалын дагуу 2023 онд хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээнд хамрагддаг 26.9 мянган өрхөөр зочлон судалгаа хийхэд АХБ-ны Цар тахлын үед хариу арга хэмжээ авах төслөөс төгрөг зарцуулсан. 2024-2025 онд босго шугамаас доош оноотой 74 мянган өрхөөр зочлон судалгаа авахад Нийгмийн халамжийн сангаас 235.0 сая төрөг зарцуулсан. Мөн Монгол Улсын нийт өрх, иргэний төрд байгаа мэдээллийг төрийн холбогдох байгууллагуудаас нэгтгэн авч өрхийн амьжиргааг үнэлэх ажил хийгдэж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны А/135 дугаар тушаалаар "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал"-ын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнийг тодорхойлох босго	100	

			шугамыг амьжиргааны түвшний үнэлгээний 401.2 болон түүнээс дээш оноогоор тогтоосон. 2025 онд уг үнэлгээнд үндэслэн ядуурлын шугамаас доош амьжиргаатай буюу нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд хүнсний эрхийг бичиг олгох, хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах, эрчим хүчний хөнгөлөлт үзүүлэх, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хөнгөлөлт үзүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлж байна. Мөн Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Ахмад настны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон дагаж өөрчлөлт орсон хуулиуд 2025 оноос хэрэгжиж эхлээд байна. Хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралтуудыг шинэчилсэн. Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 243 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Ахмад настанд дэмжлэг хөнгөлөлт олгох журам”, хоёрдугаар хавсралтаар “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг тус тус шинэчлэн батлуулсан. “Ахмад настанд дэмжлэг хөнгөлөлт олгох журам”-ыг ахмад настанд протез, ортопед, тусгай хэрэгсэл, ахмадын зориулалттай амралт сувилал, магадлан итгэмжлэгдсэн сувиллын хөнгөлөлт, түлш худалдан авах болон орон сууцны үнийн хөнгөлөлт, оршуулгын мөнгөн тусламж зэргийг нийгмийн халамжийн сангаас үзүүлэхэд мөрдөж байна. Мөн Ахмад настны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр орон нутгийн харьяалалтай ахмад настан нийслэл хотод нийтийн тээврийн хэрэгслээр зориулалтын картаар зорчих ба зорчсон төлбөрийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр зохицуулсанд нийцүүлэн Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2024 оны 246 дугаар тогтоолыг батлуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 50,5 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүнд 13,5 тэрбум төгрөгийн тусламж, хөнгөлөлтийг 2025 онд халамжийн сангаас үзүүлэхээр байна. Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн	
--	--	--	---	--

				болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн батлах тухай” 363 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-д нэмэлт оруулж, 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.		
15	3.1.5. Нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	-	Нийгмийн халамжийн тэтгэврийн нэмэгдэл 38%	Монгол Улсын Засгийн газраас хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан 2018, 2019, 2020, 2022, 2023, 2024 онуудад нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, дундаж тэтгэврийн хэмжээ 2016 онд 310.7 мянган төгрөг байсныг 787.0 мянган төгрөгт хүргэж 2.5 дахин нэмэгдүүлсэн. УИХ-аас Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд хуульд тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оноос эхлэн жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэх зохицуулалт тусгаж нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлж, Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 689,000 (зургаан зуун наян есөн мянга) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572,400 (таван зуун далан хоёр мянга дөрвөн зуу) төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээний хүрээнд дундаж тэтгэвэр 851.0 мянган төгрөгт хүрсэн.	100	
Зорилт 3.2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ:						
16	3.2.1. Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулдаг тогтолцоог бий болгоно.	-	-	Үндэсний баялгийн сангийн тухай хууль Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Тус хуулиар газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлэх замаар тэгш, шударга хүртээх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байхаар тооцож, хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг иргэн бүрд тэгш хуваарилж, уг мөнгөн хөрөнгийг хуримтлалын сангаар дамжуулан иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэхээр хуульчилсан. Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах чиглэлээр Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны ажлын алба болон Монголбанк бусад холбогдох байгууллагуудын	90	

		төлөөлөл хамтран орон сууц, ипотекийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаа улс орны сайн жишгийг судалж, орон сууцны санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх арга хэмжээний саналын төслийг боловсруулан ажиллаж байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Монголбанк, Монголын ипотекийн корпораци, Монголын банкны холбоо, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв, Нийслэлийн орон сууцны корпораци, Төрийн орон сууцны корпораци, Зээлийн батлан даалтын сан зэрэг холбогдох байгууллагууд хамтран “Хуримтлалын сан ба орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилт”-ийн талаар санал, загварын танилцуулгыг боловсруулж 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Ерөнхий сайдад, 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Үндэсний баялгийн сайн, орон сууцжуулалтын үндэсний хорооны хуралд тус тус танилцуулсан. Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайд “Залуу гэр бүлд зориулсан орон сууцны зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” танилцуулга хийсэн. Ипотекийн зээлийн бүтээгдэхүүнд нэн тэргүүнд хамрагдах орон сууцгүй, 1 ба түүнээс дээш хүүхэдтэй, ажил эрхэлдэг, өрхийн сарын орлого нь 1-2 сая төгрөг хүртэл, 40 ба түүнээс доош насны өрхийн тэргүүлэгчтэй зорилтот 17,292 өрхийн мэдээллийг боловсруулан үүнээс дахин төлөвлөлт, нийслэлийн төсөл, дэд төвийн бүсүүдэд амьдарч 4,092 өрхийн мэдээллийг гаргаж Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороонд хүргүүлсэн. Зорилтот бүлгийг тодорхойлох судалгааны хүрээнд анх удаа орон сууц авч буй залуу болон олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлийг тус тус орлогын түвшин, байршлаар тодорхойлсон болно. Мөн Хуримтлалын санд төвлөрүүлсэн эх үүсвэрийг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах зорилгоор хөрөнгө оруулалтад оруулж болно гэж заасны дагуу 2024, 2025 онд төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрт хөрөнгө оруулан ажиллаж байна. 2024 оны тухайд хөрөнгө оруулахтай холбогдох үйл ажиллагаа болон Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрхийг Монголбанканд гэрээгээр олгосны дагуу хуримтлалын санд төвлөрсөн мөнгөн хөрөнгөнөөс 9 банкаар дамжуулан 480.2 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн санхүүжилтэд олгосон. Хуримтлалын сангийн эх үүсвэрээр 4,158 өрх ипотекийн зээлд хамрагдсан бөгөөд үүнээс нийслэлд 2,149 өрх, орон нутагт 2,009 өрх байна. Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай	
--	--	---	--

				хуулиар хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 2025 онд энэхүү эх үүсвэрийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрт хөрөнгө оруулалахаар төлөвлөн ажиллаж байна. Монгол Улсын засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Орон сууцны бодлого нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх хүрээний асуудал тул нэмж тайлагнана.		
Зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ:						
17	3.3.1. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.	4,4 тэрбум	3,3 тэрбум	Хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг сайжруулж, тогтвортой ажлын байрыг бий болгох зорилтын хүрээнд хүн амын бүлгүүдэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажилласан. Тодруулбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүдэд зориулсан хөтөлбөр арга хэмжээг ХЭҮЗ-ийн тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнээс: -Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд 2021-2025 оны 5 дугаар сарын байдлаар нийт 4.4 тэрбум төгрөг төсөвлөж 3.3 тэрбум төгрөгийг зарцуулж, 17747 иргэнийг хамруулсан. Төслийн хүрээнд шилдэг старт апп залуучуудыг улсын хэмжээнд сонгон шалгаруулж, санхүүгийн дэмжлэг олгодог. Түүнчлэн Монгол Улсын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын санхүүжилттэй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ҮЕР төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү төслийн хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, хүний нөөцийн бодлого, бүтээмж, ажлын байрны менежментийг сайжруулах арга хэрэгслийг түгээн дэлгэрүүлж, холбогдох сургалтуудыг зохион байгуулж ажиллах бөгөөд ноос ноолуур болон зочлох үйлчилгээний салбарт туршин хэрэгжүүлэх юм. Азийн хөгжлийн банкны “Мэдлэгт тулгуурлан төсөлд инноваци, туршлагыг нэвтрүүлэх нь” техник туслалцааны төслийн дэмжлэгтэйгээр Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх судалгааны ажлыг хийхээр Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/156 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Энэхүү судалгааг 2025 оны 7 дугаар сард багтаан дуусгах бөгөөд 9 дүгээр сард хийхээр төлөвлөсөн Залуучуудын нэгдсэн форумд танилцуулна. Нэгдсэн форумгаар	90	

				залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлгээс гарсан асуудлыг бодлогын баримт бичигт тусгаж, хууль эрхзүйн орчны хүрээнд мөн хэрэгжилтийн түвшинд шийдвэрлэж ажиллахаар төлөвлөж байна.		
ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ						
Зорилго 4. Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ:						
Зорилт 4.1. Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ:						
18	4.1.4. Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлтийг тасралтгүй нэмэгдүүлнэ.	289,3 тэрбум	187,8 тэрбум	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хуралдаанаар жил бүр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг батлуулж, хэрэгжүүлж байна. тухайлбал, 2021- 2025 онд Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа, Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, Түр ажлын байрыг дэмжих болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа зэрэг хөтөлбөр, үйл ажиллагааг батлуулсан. 2021-2025 оны 5 дугаар сарын байдлаар дээрх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох хүрээнд 248861 хүнийг хамруулж, 289,3 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөснөөс 197506 хүнийг хамруулж, 187,8 тэрбум төгрөг зарцуулж, 119892 түр болон байнгын ажлын байрыг бий болгосон байна. Түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхлэгч, гарааны бизнес эрхлэгчийг дэмжих жижиг, дунд бизнесийг дэмжих зээл, зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 267 дугаар тогтоолоор батлуулсан.	100	
Зорилт 4.3. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ:						
19	4.3.2. Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдэж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.			Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн хэдий ч Улсын Их Хурлын	90	

			2024 оны хаврын чуулганаар хэлэлцэж амжаагүй буцаан татагдсан болно. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/48 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хамтран батлахаар 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/374 дүгээр албан бичгээр Сангийн сайдад, 2025 оны 02 дугаар 25-ны өдрийн 01/637 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж, үзэл баримтлалыг хамтран баталсан. Хуулийн төсөлд яамны газар, хэлтэс, ажлын хэсгийн гишүүн байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусгаж ажилласан. Мөн хуулийн төслийн явцын танилцуулгыг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж, өргөтгөсөн ажлын хэсгийн хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр хийж хуулийн төслийг эцэслэн хэлэлцэж дууслаа. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн болон дагалдах хуулийн төсөлд Засгийн газрын гишүүд, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкнаас санал авахаар 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/1446 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж, ирүүлсэн саналыг тусгасан. Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд-д өргөн мэдүүлэхийг дэмжлээ. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн тус хуулийн төсөлтэй уялдуулан дагах 13 хуулийн төсөл боловсруулж, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын тухай олон улсын туршлага, одоо зах зээл ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн талаарх судалгааг боловсруулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, хувийн нэмэлт тэтгэвэр олгох, тэтгэвэр өвлүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих, талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулна. Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа нь сайн дурын, шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлалын байх, үйл ажиллагаа, засаглал ил тод байх, санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байх, өвлөгддөг байх зарчмыг баримтлан ажиллахаар хуулийн төсөлд тусгасан. Сангийн яамнаас тайлан гаргадаг.		
Зорилго 7. ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ					

Зорилт 7.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ:

20	7.3.6. Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.	23,6 тэмбум /Шинээр ажиллаж эхэлсэн 833 Нийгмийн ажилтны цалин хөлс+НДШ /	20,8 тэрбум	1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан 7 төрлийн тусламж, үйлчилгээг 2020 онд 30 түр хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан үзүүлж байсан бол 2025 онд 39 түр хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан үзүүлж байна. 2020 онд нийт 3715 иргэнээс 2147 хүүхэд, 168 насанд хүрэгч, 2021 онд 4573 иргэнээс 2916 хүүхэд, 1657 насанд хүрэгч, 2022 онд 4795 иргэнээс 3226 хүүхэд, 1569 насанд хүрэгч, 2023 онд 2730 иргэнээс 2159 хүүхэд, 571 насанд хүрэгч, 2024 онд 4611 иргэнээс 3073 хүүхэд, 1809 насанд хүрэгч, 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2076 иргэнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлснээс 864 насанд хүрэгч, 1212 хүүхэд тус тус үйлчлүүлсэн бөгөөд 2020-2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 22500 иргэн түр хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн байна. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан “Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам”, ХНХ-ын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”, “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019” стандарт, ХНХ-ын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-ыг тус тус мөрдөн ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой ажилладаг ТХБ, НЦҮТ-ийн албан хаагчдыг кейс үйлчилгээний арга зүй, нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйгээр хангах сургалтыг тогтмол зохион байгуулж, 2020-2024 онуудад нийт давхардсан тоогоор нийт 1465 орчим албан хаагчдыг чадавхжуулсан. 2.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хөгжлийг дэмжих сургалт хөгжлийн үйлчилгээг 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд гэр бүлд зөвлөгөө өгөх 4 төв, 27 танимаар дамжуулан хүргэж, жил бүр нийт гэр бүлийн 40 гаруй хувьд үйлчилдэг. Энэ хүрээнд гэр бүлийн боловсрол олгох 8 модуль цахим хичээлийг бэлтгэн түгээсэн. Мөн E-Mongolia системд гэр бүлд зөвлөгөө мэдээлэл өгөх E Family цахим платформыг хөгжүүлэлтийг эхлүүлж, гэр бүлүүд өөрт хэрэгцээтэй мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлж байна. 2021 онд www.Etuslamj.mn-ын хөгжүүлэлт хийж, 2021-2022 оны хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, насанд хүрэгчдийн үйлчилгээний мэдээллийг бүртгэсэн боловч цаашид ашиглах боломжгүй нөхцөл үүссэн тул 2024 онд ГБХНХЯ, ДЗМОУБ-тай хамтран, Хүүхэд хамгааллын компакт төслийн санхүүжилтээр хүн	90	
----	--	---	-------------	---	----	--

			худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн үйлчилгээний бүртгэл, ТХБ/НЦҮТ-ийн үйлчлүүлэгчдийн бүртгэл гэсэн 2 модуль бүхий ХИМС /хохирогч иргэдийн мэдээллийн сан/ программыг хэрэглээнд нэвтрүүлсэн. Хэрэглэгчдийн нэгдсэн сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт 140 албан хаагчийг хамруулан үйлчилгээний мэдээллийг цахимаар бүртгэж байна. 3. МУ-ын Их Хурлаас 2024 оны 1-р сард Хүүхэд хамгааллын тухай хууль баталсан. Энэ хуулинд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, аюулын үед шурхай тусламж үзүүлэх зорилгоор хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтныг анхан шатны нэгжид ажиллуулах зохицуулалт анх удаа хуульчлагдсаны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоолоор “Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоо”-г нийслэлд 268, орон нутагт 565, нийт 833 албан хаагч ажиллахаар батласан. 2025 оны 05-р сарын 31-ний өдрийн байдлаар 730 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг сонгон шалгаруулж, ажилд томилон, мэргэжлийн удирдлагаар ханган, ажиллаж байна. 4. Хүүхэд хамгааллын тухай хуульд /шинэчилсэн найруулга/ “АСРАЛТ ГЭР БҮЛ”-ийн хувилбарыг шинээр хуульчилж өгсөн. Гэр бүлийн орчинд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үр дүнд хүрээгүй, эсхүл уг үйлчилгээг гэр бүлийн орчинд үзүүлэх нь хүүхдийн эрхэд хор хохирол учруулахаар байгаа тохиолдолд гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлнэ. “Гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ: 1.Нэн тэргүүнд хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах; 2.Төрөл садны гэр бүл байхгүй бол хүүхдийг асралт гэр бүлд асруулах; 3.Эхний 2 үйлчилгээнд хамруулах боломжгүй бол Асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах” хувилбарыг хуульчиллаа. 4.1.12-т “”асралт гэр бүл” гэж энэ хуульд заасан үндэслэлээр гэр бүлээсээ тусгаарлагдсан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг гэрээнд заасан хугацаанд асран халамжилж байгаа хүүхдийн төрөл, садны биш гэр бүлийг;” гэж хуульчилсан. Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэн Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.3, 8.2.10, 13.2.2. 191 дүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт орсон. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дараах журам, стандартыг батлаад байна.	
--	--	--	--	--

				❖ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/33 дугаар тушаалаар "Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам"-ыг шинэчлэн баталсан. ❖ Хүүхэд хамгааллын тухай хуультай нийцүүлэн Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний нийтлэг шаардлагыг шинэчлэн боловсруулж, MNS 5852:2025, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага батлагдаж, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. ❖ ЗГ-ын 2024 оны 236 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив”-ыг батлан мөрдүүлж байна. ❖ Асралт гэр бүл бэлтгэх сургалтын 2 төрлийн гарын авлага боловсруулж байна. - Асралт гэр бүлийг бэлтгэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд шаардагдах хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг холбогдох зардлын аргачлал, нормативын дагуу тооцоолж, 2026 оны төсвийн урьдчилсан мэдүүлэгт тусгасан		
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ						
Зорилго 9.1. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.						
21	9.1.1. Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	-	-	2019 онд нийт 19 түр хамгаалах байр, 11 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байсан бол 2025 оны 5 сарын байдлаар 22 түр хамгаалах байр, 17 нэг цэгийн үйлчилгээний төв бий болж ажиллаж байна. 5 жилийн хугацаанд 3 түр хамгаалах байр, 6 нэг цэгийн үйлчилгээ төв нэмэгдэж хамгаалах байрны хүртээмж нийт 9-өөр нэмэгдсэн байна. 2021 онд 2503 хүн, 2022 онд 3715 хүн, 2021 онд 4573 хүнд, 2022 онд 4392 хүнд, 2024 онд нийт 3502 хүнд тус тус хамгаалах үйлчилгээ үзүүлсэн байна. 2025 оны эхний 4 сарын байдлаар нийт 2076 иргэнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлснээс 864 насанд хүрэгч, 1212 хүүхэд үйлчилгээнд хамрагдсан.	100	
					90.5	